



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 02 сарын 02-ны
өдрийн 6587 дугаарт бүртгэв.

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Энгийн хог хаягдлын
үйлчилгээний хураамжийн хэмжээг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.14 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг нэгдүгээр, айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар, энгийн хог хаягдлыг захиалгаар тээвэрлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг гуравдугаар, энгийн хог хаягдлыг тээвэрлэх тариф, дундаж зайн хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, дүүргийн аж ахуй нэгж байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд, айл өрхөд сурталчлан, дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай.

3. Шинэчлэн баталсан тарифын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний төлбөр хураамжийг дүүргийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай.


4. Энэ тогтоол "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдэж, хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ
ХУУЛБААРЧ
Эрхлэгч: 
2024 он 02 сар 12 өдөр


1159100079

5.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны
өдрийн 24 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх энгийн
хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний
хураамжийн хэмжээ

Д/д	Аж ахуй нэгж, байгууллагын төрөл	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
Нэг. Нийтийн хоол, зочид буудал, аялал жуулчлалын байгууллагууд		
1.1	Зоогийн газар, кафе, цайны газар	
1.1.1	8-50 хүртэлх суудалтай	60,000
1.1.2	51-100 хүртэлх хүний суудалтай	100,000
1.1.3	101-ээс дээш хүний суудалтай	250,000
1.2	Ресторан, бар, караоке, диско клуб, шөнийн цэнгээний газар	
1.2.1	50 хүртэлх хүний суудалтай	90,000
1.2.2	51-100 хүртэлх хүний суудалтай	120,000
1.2.3	101-ээс дээш хүний суудалтай	200,000 /нэг рейсийн үнэ/
1.3	Зочид буудал	
1.3.1	16 хүртэлх ортой	85,000
1.3.2	17-30 хүртэлх ортой	15,0000
1.3.3	31-ээс дээш ортой	250,000
Хоёр. Худалдаа үйлчилгээний салбар		
2.1	6 нэрийн хүнсний дэлгүүр /А бүс буюу 1-6 дугаар хороо/	60,000
	6 нэрийн хүнсний дэлгүүр /Б бүс буюу 7-24 дүгээр хороо/	40,000
2.2	8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 м ² хүртэл/	100,000
2.3	8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 м ² хүртэл болон Супермаркет/	130,000
2.4	Хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 200 м ² -аас дээш Хайпермаркет/	150,000 /нэг рейсийн үнэ/
2.5	Хүнсний мухлаг, павильон, ТҮЦ	40,000
2.6	Хүнсний зах	150,000 /нэг рейсийн үнэ/
2.7	Барааны зах	150,000 /нэг рейсийн үнэ/
2.8	Их дэлгүүр	2,000,000
2.9	Бичиг хэрэгсэл, ном, гоо сайхан, гэр ахуйн барааны дэлгүүр	50,000
2.10	Тавилга, мебелийн дэлгүүр	80,000
2.11	Комиссын барааны дэлгүүр	30,000

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ
ХУУЛБААР
Эрхлэгч: 
2024 он 01 сар 22 өдөр

2.12	Сэлбэгийн дэлгүүр	50,000
2.13	Биллиард, теннис	50,000
2.14	Биллиард, теннис /НХАТ төлдөг/	60,000
2.15	Компьютер тоглоомын газар	60,000
2.16	Гоо сайхны салон	60,000
2.17	Канон, компьютер, интернет үйлчилгээний газар, зурагчин	40,000
2.18	Саун, массаж	70,000
2.19	Халуун ус	60,000
2.20	Үсчин	50,000
2.21	Хувцас захиалга засвар /Оёдол эсгүүр, гутал засвар/	35,000
2.22	Алт мөнгөний дархан	50,000
2.23	Түүхий эд хүлээн авах цэг /Шил, лааз, хуванцар, яс бусад/	40,000
2.24	Шатахуун түгээх станц	100,000
2.25	Нефтийн агуулах	150,000
2.26	Нотариат	30,000
2.27	Ломбард /бусад/	50,000
2.28	Ломбард /Алт мөнгөний/	40,000
2.29	Ломбард /Авто машины/	60,000
2.30	Ил задгай худалдаа эрхлэгчид /хүнс, жимс, түлээ нүүрс, бусад/	30,000
2.31	Машин угаалга	80,000
2.32	Дугуй засвар /Ахуйн хог суурь үнээр/	100,000
2.33	Шуудан холбооны газар	75,000
2.34	Өрхийн үйлдвэрлэл	20,000
2.35	Жижиг үйлдвэрлэл /Хэвлэл, савхи даавуун эдлэл, мод, төмөр, шил шаазан эдлэлийн үйлдвэрлэл, арьс шир, ноос, ноолууран эдлэлийн үйлдвэрлэл /	80,000
2.36	Хүнсний үйлдвэрлэл	150,000 /нэг рейсийн үнэ/
2.37	Өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	150,000 /нэг рейсийн үнэ/
2.38	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	150,000 /нэг рейсийн үнэ/
2.39	Гурилан бүтээгдэхүүний үйлдвэр	150,000 /нэг рейсийн үнэ/
2.40	Эсгий, ноос боловсруулах цех	85,000
2.41	Дахин боловсруулах үйлдвэр	150,000
2.42	Вакум цонх хаалганы үйлдвэр /Шилнээс бусад хог/	150,000
2.43	Барилгын хавтан блокийн үйлдвэр	150,000 /нэг рейсийн үнэ/
2.44	Машин засвар, кузов засвар	130,000
Гурав. Боловсролын салбар		
3.1	Их, дээд сургууль	150,000 /нэг рейсийн үнэ/
3.2	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ясли	130,000

ЧИНГЭЛТЭН
 ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
 ХУГАЛ
ХУУЛБАРТЭН
 Эрхлэгч:
 2024.01.01 сар 2 өдөр

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн 22 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын
үйлчилгээний хураамжийн хэмжээ

№	Нэр төрөл	Нэг сард ногдох /төгрөгөөр/
1	Айл өрх	8,000₮

Тайлбар: Нэг өрхийн ам бүлийн тоог тухайн жилийн хүн амын тооллогын
статистик үзүүлэлтийг үндэслэн дунджаар 4 хүнтэй байхаар тооцсон.



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 24-ны
өдрийн 2 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

Энгийн хог хаягдлыг захиалгаар тээвэрлэх үйлчилгээний
хураамжийн хэмжээ

№	Хэмжээ	Хог хаягдал захиалгаар тээвэрлэх үйлчилгээний хураамж /төгрөгөөр/
1	1 куб. метр	35,000₮

Тайлбар: Барилгын болон уурын зуухнаас үүсэх хог хаягдлыг захиалгаар хог
тээвэрлэх хураамжаар тооцно.



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн 12 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тариф,
дундаж зайн хэмжээ

Д/д	Хороодын дугаар	Нэг километрт нэг тонн энгийн хог хаягдлыг тээвэрлэх тариф /төгрөгөөр/	Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай /км/
1	1 дүгээр хороо	1,800	26
2	2 дугаар хороо	1,800	26
3	3 дугаар хороо	1,800	26
4	4 дүгээр хороо	1,800	26
5	5 дугаар хороо	1,800	26
6	6 дугаар хороо	1,800	26
7	7 дугаар хороо	1,800	26
8	8 дугаар хороо	1,800	26
9	9 дүгээр хороо	1,800	26
10	10 дугаар хороо	1,800	26
11	11 дүгээр хороо	1,800	26
12	12 дугаар хороо	1,800	26
13	13 дугаар хороо	1,800	26
14	14 дүгээр хороо	1,800	26
15	15 дугаар хороо	1,800	26
16	16 дугаар хороо	1,800	26
17	17 дугаар хороо	1,800	26
18	18 дугаар хороо	1,800	26
19	19 дүгээр хороо	1,800	26
20	20 дугаар хороо	1,800	26
21	21 дүгээр хороо	1,800	26
22	22 дугаар хороо	1,800	26
23	23 дугаар хороо	1,800	26
24	24 дүгээр хороо	1,800	26

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУГАА
ХУУЛБАР
Эрхлэгч: 
2024 он 01 сар 12 өдөр